

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН
2012 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.11.12


Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2012 оны гуравдугаар улиралд Хороо 8 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 1 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 205 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

Тайлант хугацаанд Хорооны хуралдааны шийдвэрээр 1 ББСБ-ын банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон ба 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:



2012 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлан, мэдээний нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 1/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны III улирал	2012 оны III улирал	Өсөлт /+/, бууралт /-/
1	ББСБ-ын тоо	192	205	13
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	599	594	-5
3	Ажиллагсадын тоо	976	1,137	161
4	Салбар нэгжийн тоо	51	63	12
5	Харилцагчдын тоо	137,376	209,590	72,214
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	189,103,738.2	245,386,298.8	56,282,560.6
Банкны салбарт эзлэх хувь		2.31%	2.23%	0.1%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	107,940,478.3	154,406,025.7	46,465,547.4
Банкны салбарт эзлэх хувь		2.15%	2.23%	-0.1%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	123,484,269.2	162,240,121.3	38,755,852.1
Банкны салбарт эзлэх хувь		21.86%	17.87%	-4.0%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	105,730,915.0	133,289,227.1	27,558,312.1
Банкны салбарт эзлэх хувь		42.39%	44.89%	2.5%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	9,220,540.6	15,726,070.9	6,505,530.3

11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	31,690,990.2	46,049,831.7	14,358,841.5
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	24,312,450.2	32,596,565.3	8,284,115.1
13	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	7,378,540.0	13,453,266.4	6,074,726.4
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	16	17	1
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		8.33%	8.29%	-0.04%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	27,186,510.3	41,670,191.3	14,483,681.0
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		14.38%	16.98%	2.6%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	19,975,259.6	27,109,092.0	7,133,832.4
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		18.51%	17.56%	-0.95%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	14,013,385.8	26,139,907.4	12,126,521.6
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		11.35%	16.11%	4.76%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	11,150,932.5	21,098,562.5	9,947,630.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		10.55%	15.83%	5.28%
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	23	22	-1
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		11.98%	10.73%	-1.25%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	4,762,525.7	5,513,985.6	751,459.9
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		2.52%	2.25%	-0.27%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,529,411.4	4,204,834.1	675,422.7
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		3.27%	2.72%	-0.55%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	4,392,543.6	5,104,786.6	712,243.0
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		3.56%	3.15%	-0.41%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,428,621.7	4,092,872.1	664,250.4
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		3.24%	3.07%	-0.17%
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	42	38	-4
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		21.88%	18.54%	-3.34%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,804,909.2	7,111,413.7	1,306,504.5
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		3.07%	2.90%	-0.17%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,680,795.1	6,981,762.6	1,300,967.5
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		4.60%	4.30%	-0.3%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	4,843,942.4	5,674,942.4	831,000.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		4.58%	4.26%	-0.32%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2012 оны гуравдугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 17 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.3 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 17.0 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 17.6 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 16.1 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 15.8 хувийг тус тус эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 9, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2012 оны гуравдугаар улирлын байдлаар орон нутагт төвтэй 22 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 10.7 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 2.2 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-ын олгосон зээлийн 2.7 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.1 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.1 хувийг тус тус эзэлж байна.

Валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

Валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 18.5 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 2.9 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.3 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2011 оны III улирал	2012 оны III улирал
1	Зээл	147	164
2	Факторингийн үйлчилгээ	11	12
3	Төлбөрийн баталгаа гаргах	8	8
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	5
6	Гадаад валютын арилжаа	96	92
7	Итгэлцлийн үйлчилгээ	16	18
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	3	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	13	16
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

2012 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 4 ББСБ эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 1 ББСБ өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр тус тус хамрагдлаа.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант улиралд нийт ББСБ-уудын активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд

/Хүснэгт 3/

№	ХӨРӨНГӨ	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь

А	Эргэлтийн хөрөнгө	182,450,640.0	96.5%	236,516,334.5	96.4%	54,065,694.5	29.6%
1	Мөнгөн хөрөнгө	61,257,952.9	32.4%	70,909,105.1	28.9%	9,651,152.2	15.7%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	3,264,416.9	1.7%	2,196,615.7	0.9%	-1,067,801.2	-32.7%
3	Нийт зээл	107,940,478.3	57.1%	154,406,025.7	62.9%	46,465,547.4	43.0%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,216,177.0	2.2%	4,415,536.6	1.8%	-199,359.6	4.7%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	2,237,285.0	1.2%	613,089.9	0.2%	-1,624,195.1	-72.6%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
5	Нийт факторингийн тооцооны авлага	1,929,780.0	1.0%	939,120.0	0.4%	-990,660.0	-51.3%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	532,987.2	0.3%	870,316.2	0.4%	337,329.0	63.3%
7	Бусад хөрөнгө	8,809,893.8	4.7%	10,997,598.5	4.5%	2,187,704.7	24.8%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	694,023.0	0.4%	0.0	0.0%	-694,023.0	-100.0%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	6,653,098.1	3.5%	8,869,964.4	3.6%	2,216,866.3	33.3%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	6,653,098.1	3.5%	8,869,964.4	3.6%	2,216,866.3	33.3%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	8,625,516.2	4.6%	11,483,013.0	4.7%	2,857,496.8	33.1%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,972,418.0	1.0%	2,613,048.7	1.1%	640,630.7	32.5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		189,103,738.2	100.0%	245,386,298.8	100.0%	56,282,560.6	29.8%

Тайлант хугацаанд нийт активын 62.9 хувийг зээл, 28.9 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж энэ нь дүнгээрээ нийт активын 91.8 хувийг бүрдүүлж байгаа нь ББСБ-ын салбарын гол үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа болохыг харуулж байна.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	Ангилал	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	98,800,459.1	91.5%	144,250,247.2	93.4%	45,449,788.1	46.0%
2	Хугацаа хэтэрсэн	2,889,025.4	2.7%	4,163,519.7	2.7%	1,274,494.3	44.1%
3	Чанаргүй зээл. Үүнээс	6,250,993.7	5.8%	5,992,258.7	3.9%	-258,735.0	-4.1%
	Хэвийн бус	1,662,697.7	1.5%	1,537,629.9	1.0%	-125,067.8	-7.5%
	Эргэлзээтэй	1,529,837.5	1.4%	1,308,157.9	0.8%	-221,679.6	-14.5%
	Муу	3,058,458.5	2.8%	3,146,470.9	2.0%	88,012.4	2.9%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,216,177.0	3.9%	4,415,536.6	2.9%	199,359.6	4.7%
	Нийт зээл	107,940,478.3	100.0%	154,406,025.7	100.0%	46,465,547.4	43.0%

2012 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 46,465,547.4 мянган төгрөгөөр буюу 43.0 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 46.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 258,735.0 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурч нийт зээлийн дүнд эзлэх чанаргүй зээлийн хувь 3.9

хувь болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувиар буурч чанаржсан эерэг үзүүлэлттэй байна.

2.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй нийт 205 ББСБ-аас 80,0 хувь буюу 164 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж дээд хүү 4.17 хувь, зээлийн дундаж доод хүү 2.04 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.1 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 3/



ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-ын салбарын 2012 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	51,070,116.5	27.0%	73,040,854.2	29.8%	21,970,737.7	43.0%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	9,220,540.6	4.9%	15,726,070.9	6.4%	6,505,530.3	70.6%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	33,910,198.5	17.9%	48,891,638.1	19.9%	14,981,440.1	44.2%
3	Бусад эх үүсвэр	2,814,332.6	1.5%	3,002,943.3	1.2%	188,610.7	6.7%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	0.0	0.0%	600.0	0.0%	600.0	100.0%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,730,754.2	1.4%	2,968,531.5	1.2%	237,777.3	8.7%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	79,879.0	0.0%	33,811.8	0.0%	-46,067.2	-57.7%
	Факторингийн үйлчилгээний өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0%	0.0	0.0%	-3,699.4	-100.0%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	400,000.0	0.2%	0.0	0.0%	-400,000.0	-100.0%
5	Төслийн зээлийн санхүүжилт	4,725,044.8	2.5%	5,420,201.9	2.2%	695,157.1	14.7%
	Бусад өр төлбөр	14,549,352.4	7.7%	10,105,323.3	4.1%	-4,444,029.10	-30.6%
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,533,822.6	1.3%	2,460,434.0	1.0%	-73,388.6	-2.9%

7	Бусад пассив	11,311,073.3	6.0%	7,644,889.3	3.1%	-3,666,184.0	-32.4%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	704,456.5	0.4%	0.0	0.0%	-704,456.5	-100.0%
	Нийт өр төлбөр	65,619,469.0	34.7%	83,146,177.5	33.9%	17,526,708.5	26.7%
Б	Эзэмшигчдийн өмч	123,484,269.2	65.3%	162,240,121.3	66.1%	38,755,852.1	31.4%
9	Хувьцаат капитал	105,730,915.0	55.9%	133,289,227.1	54.3%	27,558,312.1	26.1%
10	Бусад өмч	2,742,166.3	1.5%	4,002,716.0	1.6%	1,260,549.7	46.0%
11	Сангууд	1,130,538.6	0.6%	1,180,841.6	0.5%	50,303.0	4.4%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	11,216,135.1	5.9%	21,199,030.2	8.6%	9,982,895.1	89.0%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,664,514.1	1.4%	2,568,306.4	1.0%	-96,207.7	-3.6%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	189,103,738.2	100.0%	245,386,298.8	100.0%	56,282,560.6	29.8%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 29.8 хувиар, эзэмшигчдийн өмч 31.4 хувиар тус тус өссөн бөгөөд 2011 оны гуравдугаар улирлын тайлангаар нийт эх үүсвэрийн 34.7 хувийг нийт өр төлбөр, 65.3 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2012 оны гуравдугаар улиралд нийт өр төлбөр 33.9 хувь, эзэмшигчийн өмч 66.1 хувь байна. Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2012 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 73 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 6/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	ХҮҮГИЙН ОРЛОГО	21,311,060.5	67.2%	31,634,081.4	68.7%	10,323,020.9	48.4%
1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	19,744,428.6	62.3%	29,953,746.5	65.0%	10,209,317.9	51.7%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	428,326.7	1.4%	747,659.0	1.6%	319,332.3	74.5%
	Үнэт цаасны хүүгийн орлого	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	Бусад хүүгийн орлого	1,138,305.1	3.6%	932,675.9	2.0%	-205,629.2	-18.7%
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	9,766,565.9	30.8%	13,298,346.0	28.9%	3,531,780.1	36.2%
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	606,765.6	1.9%	1,010,573.0	2.2%	403,807.4	66.5%
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	6,598.2	0.0%	106,831.3	0.2%	100,233.1	16.2 дахин
	НИЙТ ОРЛОГО	31,690,990.2	100.0%	46,049,831.7	100.0%	14,358,841.5	45.3%

2012 оны гуравдугаар улирлын орлого өмнөх оны мөн үеэс 45.3 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлт зэрэг нь үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж улмаар үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлогын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна.

Тайлант хугацааны нийт орлогын 68.7 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 48.4 хувиар өссөн/, 28.9 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 36.2 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.2 хувиар өссөн байна. Үүнд:

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	4,108,055.0	42.1	4,499,768.4	33.8	391,713.4	9.5
1.1	Гадаад валютын арилжааны орлого	3,605,482.9	36.9	3,620,687.2	27.2	15,204.3	0.4
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	502,572.1	5.1	879,081.2	6.6	376,509.1	74.9
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	3,654,258.3	37.4	5,747,518.3	43.2	2,093,260.0	57.3
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	3,649,718.0	37.4	4,954,803.9	37.2	1,305,085.9	35.7
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	4,540.3	0.0	792,714.4	6.0	788,174.1	174.5 дахин
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	2,004,252.7	20.5	3,051,059.3	22.9	1,046,806.6	52.2
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	4,364.4	0.0	0.0	0.0	-4,364.4	-100.0
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	2,032.1	0.0	0.0	0.0	-2,032.1	-100.0
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	546,861.3	5.6	648,734.4	4.9	101,873.1	18.6
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	66,100.5	0.7	76,303.7	0.6	10,203.2	15.4
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	967,486.3	9.9	1,559,166.1	11.7	591,679.8	61.1
3.7	Бусад	417,408.1	4.3	766,855.1	5.8	349,447.0	83.7
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	9,766,565.9	100.0	13,298,346.0	100.0	3,531,780.1	136.2

Нийт зардлын бүтцүүд дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.09.30		2012.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	3,634,308.3	14.9%	4,772,361.8	14.6%	1,138,008.5	31.3%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	17,350,960.0	71.4%	23,610,022.6	72.4%	6,259,062.6	36.1%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,918,631.2	7.9%	1,833,439.1	5.6%	-85,192.1	-4.4%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	429,200.7	1.8%	671,952.1	2.1%	242,751.4	56.5%
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	193.2	0.0%	16,843.0	0.1%	16,649.8	87.2 дахин
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	979,156.8	4.0%	1,691,946.7	5.2%	712,789.9	72.8%
	НИЙТ ЗАРДАЛ	24,312,450.2	100.0%	32,596,565.3	100.0%	8,284,115.1	34.1%

Нийт зардал өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар өссөн нь ББСБ-уудын бусдаас татсан эх үүсвэрт төлөх хүүгийн зардал 31.3 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 56.5 хувиар, орлогын татварын зардал 72.8 хувиар тус тус өссөн байгаа нь шууд нөлөө үзүүлсэн байна.

ББСБ-ууд нь 2012 оны гуравдугаар улиралд нийт 13,453,266.4 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 82.3 хувийн өсөлттэй байна.

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.09.30	2012.09.30	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	31,690,990.2	46,049,831.7	14,358,841.5

2	НИЙТ ЗАРДАЛ	24,312,450.2	32,596,565.3	8,284,115.1
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	7,378,540.0	13,453,266.4	6,074,726.4

ТАВ. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд нэгтгэлийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 162,240,121.3 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 172,992,857.9 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 92.1 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 93.8 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 65 хувь;

- түргэн борлогдох актив 73,519,333.3 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 58,557,281.1 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 125.5 хувь;

- активын эрсдэлийн санг 4,540,504.5 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 55,734.6 мянган төгрөгөөр илүү буюу нийт 4,596,239.1 мянган төгрөгөөр байгуулсан байна.¹;

- валютын дансны цэвэр зөрүү 7,370,206.0 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 162,240,121.3 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 4.54 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 15,726,070.9 мянган төгрөг, хувьцаат капитал 133,289,227.1 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 11.8 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,529,178.9 мянган төгрөг, нийт актив 245,386,298.8 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.03 хувь байгаа нь салбарын хэмжээнд дээрх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

- 2012 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 205 ББСБ-аас 204 ББСБ буюу 99.5 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 4 ББСБ буюу 1.9 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан байна.
- ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 56,282,560.6 мянган төгрөг буюу 29.8 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 46,465,547.4 мянган төгрөг буюу 43.0 хувь, эзэмшигчийн өмч 38,755,852.1 мянган төгрөг буюу 31.4 хувь, нийт дүрмийн сан 27,558,312.1 мянган төгрөг 26.1 хувиар тус тус өссөн.
- ББСБ-уудын нийт актив 2012 оны гуравдугаар улирлын байдлаар 245,386,298.8 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 10,968,909,686.0 мянган төгрөг/** 2.23 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 154,406,025.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн **/банкны салбарын нийт зээл 6,913,115,251.8 мянган төгрөг/** 2.23 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 5,992,258.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн **/банкны салбарын чанаргүй зээл 304,160,042.1 мянган төгрөг/** 1.97 хувь, нийт дүрмийн сан 133,289,227.1 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн **/банкны салбарын нийт дүрмийн сан 296,869,413.3 мянган төгрөг/** 44.89 хувьтай тус тус тэнцэж байна.

¹Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно. ББСБ-ын салбарын 2012 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга